

1. Та өмгөөлөгчтэй уулзаж нууц зөвлөгөө авах ба байцаалтны явцад өмгөөлөгч байлцуулах эрхтэй

A. Ямар тохиолдолд

- Байцаалтны явагдахаас өмнө та өмгөөлөгчтэй уулзаж нууц зөвлөгөө авах ба байцаалтны явцад өмгөөлөгч байлцуулах эрхтэй.
- Таны сэжиглэгдэж байгаа хуулийн зүйл анги нь хорих ял шийтгэлтэй тохиолодолд доорх С дүрэм үйлчилнэ.

B. Өмгөөлөгчийн талаар

- Та өмгөөлөгчөө сонгож болно.
- Та хөнгөлттэй болон үнэгүй өмгөөлөгч авах хуулийн шаардлагын болзолыг хангасан бол хууль зүйн тусламж үзүүлэх өмгөөлөгчийн албанаас төлбөргүй ба хөнгөлттэй өмгөөлөгч хүсэж болно. Энэ хуулийн шаардлагын болзолын тухай мэдээлэл баримтыг хүсэж болно.

C. Нууц зөвлөгөө явагдах талаар

Хэрэв та зарлан дуудах хуудас (бичгээр) хүлээн авч байцаалтанд дуудагдсан бол та дуудсан хугацаанд өмгөөлөгчийн хамт ирнэ. Зарлан дуудах хуудсанд өмгөөлөгч байлцуулах эрхийн 1-4 тухай дурдсан мэдээлэл хавсаргасан байдаг.

- Өмгөөлөгч байлцах боломжгүй шалтгаанаар байцаалтыг хойшлуулахгүй.
- Өмгөөлөгч байлцахгүй шалтгаанаас та дуугүй байх эрхийн дагуу мэдүүлэг өгөхгүй тухайгаа байцаалт эхлэхэд мэдэгдэнэ.

Хэрэв та байцаалтанд бичгэн зарлангаар дуудагдаагүй ба зарлан дуудах хуудас бүрэн бус мэдээлэлтэй байсан бол Та

- Байцаалтыг 1 удаа өмгөөлөгчид мэдэгдэгдээгүй шалтгаанаар хойшлуулж болно.
- Та өмгөөлөгчөөс утсаар нууц зөвлөгөө авч болно.
- Та байцаалт явагдах цагдаагийн хэлтэс дээр өмгөөлөгчөө хүлээж болно.

D. Өмгөөлөгч байлцах тухай

Өмгөөлөгч дараах зүйлийг хянана:

- - Таны дуугүй байх эрх ба эрүүг тулган хүлээлгэж байгаа талаар
- - Бие махбодийн буюу сэтгэл санааны дарамтад оруулж байгааг
- - Таны эрхийг талаар танд танилцуулсан ба байцаалтын үйл явцыг

Өмгөөлөгчийн гаргасан гомдолыг бичиж тэмдэглэх ёстой. Өмгөөлөгч хуулийн мөрдлөгө ба байцаалт явуулах хүсэлт гаргаж болно. Асуултыг дахин тодруулж асуухыг хүсэж болно. Байцаалтны болон мөрдлөгийн үйл ажиллагааны талаар санал гомдол хэлж болно.

Өмгөөлөгч таны өмнөөс асуултанд хариулж байцаалтанд саад учруулахыг хориглоно.

E. Өмгөөлөгчийн тусламж татгалзах

Та заавал өмгөөлөгчөөс нууц зөвлөгөө авах ба заавал байцаалтны явцад байлцуулах ёсгүй.

Та дараах тохиолодолд өмгөөлөгчийн тусламж зөвлөгөө авах эрхээсээ татгалзаж болно.

- Та насанд хүрсэн бол
- Та татгалзсан баримтанд гарын үсгээ зурж, он сар өдөр бичигдсэн бол

2. Хэргийн тухай товч мэдээлэл өгөх

- Сэжиглэгдэж байгаа хэргийн талаар танд товч мэдээлэл өгөх ёстой.

3. Дуугүй байх эрх

- Та хэргийг хүлээх албагүй
- Та өөрийгөө танилцуулсаны дараа мэдүүлэг өгөхөөс татгалзах ,асуултанд хариулах ба дуугүй байх эрхтэй.

4. Бусад эрх

Байцаалтны эхний шатанд танд дуугүй байх эрхийн тухай ,байцаалт авах шалтгааны товч тайлбарыг дахин танилцуулахаас гадна дараах зүйлийг мэдээллэнэ.

- Байцаагчын асуусан асуулт,таны хариултыг үг бүрчлэн бичихийг хүсэмжилж болно.
- Та мөрдлөгийн үйл ажилагаа явуулах,байцаалт явуулах хүсэлт гаргаж болно.
- Таны мэдүүлэг эрхээ хамгаалах бичгэн баримт болно.
- Хэрэв таныг хорьж саатуулаагүй бол та эрх чөлөөтэй хөдлөх эрхтэй.
- Та байцаалтыг хойшлуулахгүйгээр өөрт байгаа холбогдолтой гэж үзсэн баримт бичгийг өгч болно. Энэ баримт бичгүүдийг мэдүүлэгийн хамт хавтаст хэрэгт хавсаргаж шүүхийн тамгийн газар хадгалах хүсэлт гаргаж болно.

5. Байцаалтны төгсгөл

Байцаалт явагдаж дууссаны дараа та мэдүүлгийг бүрэн эхээр нь дахин уншиж болно. Эсвэл уншуулж болно.

Дараа нь танаас нэмэх ба засах зүйл байна уу гэж асууна.

6. Орчуулагчийн тусламж авах тухай эрх

- Та хуулийн үйл ажилагааг явуулах хэл сонгож болно. Итгэмжлэгдсэн орчуулагч дуудаж байцаалтыг явуулж болно. Төлбөргүй.
- Мөн та эх хэлээрээ мэдүүлгээ бичгээр өгч болно.

Энэ мэдүүлэгч иргэний эрхийн талаарх мэдээллийн хувийг танд зориулав.